



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 13 өдөр

Дугаар A/399

Мөрөн

Гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "а", 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх инженерийн хийцтэй уст цэг шинээр гаргах ажлыг өрөмдлөгийн машины эргэн төлөлтөнд шинээр гаргах инженерийн хийцтэй гүн өрмийн худгуудыг "Хөвсгөл Геологи" ХХК-аар гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсугай.

2. 2017 онд шинээр гаргах худгийн нэрсийг сум, байршлаар нь хавсралтаар баталсугай.

3. "Хөвсгөл-Геологи" ХК-тай уст цэг шинээр гаргах ажлын гэрээ байгуулах худгийн ажлын явцад хяналт тавьж, батлагдсан төсөвт өртөгт багтаан гүйцэтгүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Баттулга/-д үүрэг болгосугай.

4. Шинээр гаргах худгийн төсөвт өртгийн 5%-ийн оролцооны хөрөнгийг орон нутгаас гарган ажиллахыг холбогдох сумдын Засаг дарга нарт даалгасугай.

5. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Х.Ган-Очир/-д үүрэг болгосугай.



ДАРГА

Л.ГАНБОЛД

Аймгийн Засаг даргын 2017 оны 06
дугаар сарын 13-ны өдрийн А/399
дүгээр захирамжийн хавсралт

2017 ОНД ШИНЭЭР ХУДАГ ГАРГАХ СУМ, БАГИЙН НЭР БАЙРШИЛ

№	Сумын нэр	Багийн нэр	Худаг гаргах газрын нэр	Гүйцэтгэгч байгууллага
1	Бүрэнтогтох	4-р баг	Сургууль	"Хөвсгөл геологи" ХХК
2	Бүрэнтогтох	Туяа баг	Тултын тохой	Хөвсгөл геологи "ХХК
3	Бүрэнтогтох	Их-Уул баг	Бор гүвдээ	Хөвсгөл геологи "ХХК
4	Галт	5-р баг	Малчны хороолол	Хөвсгөл геологи "ХХК
5	Мөрөн	10-р баг	Малчны хороолол	Хөвсгөл геологи "ХХК
6	Мөрөн	1-р баг	Ирээдүй сургууль	Хөвсгөл геологи "ХХК
7	Мөрөн	10-р баг	Германы мэдээллийн төв	Хөвсгөл геологи "ХХК
8	Ренчинлхүмбэ	6-р баг	Сумын төв, Малчны хороо	Хөвсгөл геологи "ХХК
9	Арбулаг	5-р баг	Сумын төв, Малчны хороо	Хөвсгөл геологи "ХХК
10	Баянзүрх	5-р баг	Сумын төв, Малчны хороо	Хөвсгөл геологи "ХХК

ЗӨВШӨӨРСӨН:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗДТГ –ЫН ДАРГА




БАТЛАВ:

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЗАСАГ/ДАРГА



ГҮЙЦЭТГЭГЧ:

“ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ”
ХК –ИЙН ЗАХИРАЛ



УСНЫ ӨРӨМДЛӨГИЙН МАШИН ТЕХНИК, ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН ИЖ БҮРДЛИЙН ЭРГЭН ТӨЛӨЛТИЙН
АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2017 оны 06 –р сарын 13 –ны өдөр

Дугаар №

Хөвсгөл аймаг

Энэхүү гэрээг /цаашид “Гэрээ” гэх/ нэг талаас Хүнс, хөдөө аж ахуйн газар /цаашид “Захиалагч” гэх/, нөгөө талаас Хөвсгөл аймгийн “Хөвсгөл Геологи” ХК /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ нар дараах зүйлийг харилцан тохиролцож 2017 оны 06 –р сарын 13 –ны өдөр энэхүү гэрээг байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу ажил гүйцэтгэхтэй холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний зорилго ошино.
2. Гүйцэтгэгч нь Хөвсгөл аймгийн Засаг даргын 2017 оны 06 –р сарын 13 –ны өдрийн А/399 тоот захирамжаар баталсан Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын 4 –р багийн “Сургууль”, Туяа багийн “Тултын тохой”, Их-Уул багийн “Бор гүвдэй”, Галт сумын 5 –р багийн “Малчны хороолол”, Мөрөн сумын 10 –р багийн “Малчны хороолол”, 1 –р багийн “Ирээдүй сургууль”, 10 –р багийн “Германы мэдээллийн төв”, Ренчинлхүмбэ сумын 6 –р багийн “Малчны хороолол”, Арбулаг сумын 5 –р багийн “Малчны хороолол”, Баянзүрх сумын 5 –р багийн “Малчны хороолол” нийт 6 сумын 10 ширхэг инженерийн хийцтэй худаг шинээр гаргах ажлыг 2017 оны 06 –р сарын 13 –ны өдөр эхэлж 2017 оны 12 –р сарын 14 –ны өдөр захиалагчид хүлээлгэж өгнө.
3. Гүйцэтгэгч нь хайгуул хийгдээгүй цэг дээр өрөмдлөгийн ажил гүйцэтгэж ус гараагүй тохиолдолд өрөмдсөн цооногийг эргэн төлөлтийн худгийн тоонд оруулж тооцно.
4. Өрөмдсөн уст цэгийг хүлээлгэж өгснөөс хойш мөнх цэвдгээс болж уст цэг хөлдсөн тохиолдолд гүйцэтгэгч хариуцахгүй болно.